


**АУДИТЫН НЭР: 2014-2017 ОНЫ УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН
НОГДУУЛАЛТ, ТӨВЛӨРҮҮЛЭЛТИЙН БАЙДАЛ / ЖУУЛЧНЫ БААЗУУДАД/**



**ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭГЭЭР ТӨВЛӨРҮҮЛЖ БАЙГАА ХЭДИЙ Ч
ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДЭСЛЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

Агуулга:

Тайлан бэлтгэсэн: Архангай аймгийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар	3
Тэргүүлэх аудитор Х.Алтанчимэг	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
Аудитын менежер Т.Байгалмаа	Аудитын тайлан	
	БҮЛЭГ 1: 2014-2017 ОНУУДАД РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ БОДИТООР ТООЦООЛООГҮЙ БАЙНА	7-10
Аудитор Х.Алтанчимэг Г.Цог-эрдэнэ	БҮЛЭГ 2: УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ДАНСАНД БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЖ БАЙНА	10-12
	БҮЛЭГ 3: НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТООЦОХГҮЙ БАЙГАА Ч ТӨЛӨВЛӨСӨН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.	13-14
2017 оны 10 дугаар сар	Дүгнэлт	15
Уг тайланг Аудитын газрын Вэб сайт-аас үзнэ үү www.audit.mn	Зөвлөмж	16
	Уламжлах санал	17
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 70332860 дугаарын утсаар холбогдоно уу.	Тэргүүлэх аудиторын тайлан баталгаажуулсан тушаал	18-19
	Холбогдох байгууллагын санал	19-22
	Аудитын газрын тайлбар	
Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот		

Товчилсон үгийн тайлбар

АРХ	Архангай
НА	Нийцлийн аудит
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОЧГСГЗ	Орхон чулуут голын сав газрын захиргаа
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ

Аудитын нэр:

2014-2017 оны Ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтийн байдал /Жуулчны баазуудад/

Аудитын код: ААГ-2017/02-НА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилтууд:

2014-2017 онуудад Ус, рашаан ашигласны төлбөр хураамжийг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн байдлыг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазууд болон ус, рашаан ашиглагч аж ахуй нэгжийг хамруулан шалгаж аудитын дүнгээс Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх саналыг холбогдох албан тушаалтанд танилцуулан улмаар орон нутгийн удирдлагад бодит мэдээлэл өгөх, шийдвэр гаргах түвшинд туслалцаа үзүүлэхэд аудитын зорилт оршино. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Ус, рашаан ашигласны төлбөр хураамжийг хууль, тогтоомжид заасны дагуу үнэн зөв ногдуулсан эсэх,
- Уг төлбөр хураамжийг орон нутгийн төсвийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлсэн эсэх,
- Ус, рашааны төлбөр хураамжийг холбогдох хууль журамд нийцүүлэн зарцуулж дотоод хяналтын тогтолцоог бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх,

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар аймгийн ИТХ, ЗДТГ, Татварын хэлтэс түүний харьяа сумдын татварын улсын байцаагч, СТСХ, ОЧГСГЗ, БОАЖГазар түүний харьяа сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, аймагт үйл ажиллагаа явуулж буй Жуулчны баазуудыг хамруулан орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт болон хяналт шалгалтын ажлыг шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын түр журам арга зүйг ашиглан холбогдох иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны байгууллагын албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, баримт бичгийг судлах зэргээр асуудлын шинжилгээний тохирох аргазүйг ашиглана. Аудитын явцад цуглуулсан баримт материалыг шинжлэхдээ нөхцөл байдлыг хууль, тогтоомжийн үндсэн үзүүлэлттэй харьцуулах, зэрэгцүүлэх, мэдээлэл, нотлох баримтыг бүлэглэх, нэгтгэн дүгнэх, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай

нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх санал боловсрууллаа.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт, хугацаа:

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

1. Төрийн аудитын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Усны тухай хууль
4. Татварын ерөнхий хууль
5. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
6. Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоол
7. Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
8. Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”
9. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол
10. Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандартууд

Аудитыг тэргүүлэх аудитор Д.Уламбаяр удирдаж, аудитын менежер Т. Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж аудитор Х.Алтанчимэг төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Усны тухай хуулинд “ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуй нэгж байгууллагыг хэлнэ гэж заасан байдаг. Энэ дагуу 2015, 2016 оны ус, рашаан ашигласны төлбөр хураамжийг сумдаас ирүүлсэн ус, рашаан ашиглагч иргэд ААНБ-ын судалгааг үндэслэн, ЗГ-ын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг ашиглан, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Аймгийн ИТХ-ын 2012 оны 06 тоот тогтоолд заасан хураамжийн хэмжээгээр төлөвлөсөн байна.

2015-2016 онд ус, рашаан ашигласны хураамжийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Төлөвлөгөө /мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү	Хувь
2015 он	82,000.0	112,902.5	30,902.5	137.7
2016 он	323,435.3	376,057.3	52,622.0	116.3

Аймгийн хэмжээнд нийт 11 суманд 30 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн судалгааг аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн бөгөөд дээрх аж ахуй нэгжүүд ус ашигласны төлбөр хураамжийг аймгийн төсөвт, рашаан ашигласны төлбөр хураамжийг сумын төсөвт төвлөрүүлж байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “хоногт 100 шоомтрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоомтр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоомтр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв цөөрөм байгуулах, суваг шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана” гэж заасны дагуу үйл ажиллагаа эрхэлж буй жуулчны баазууд /Цэнхэр суманд үйл ажиллагаа явуулж буй бааз/ ус ашиглах дүгнэлтийг гаргуулах ёстой боловч 2015,2016 онуудад дүгнэлт гаргуулж ажиллаагүй байна.

2017 оны тухайд ус ашигласны төлбөрийн орлогыг **188.3** сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр **31.8** сая төгрөг, рашааны ашигласны төлбөрийн орлогыг **27.8** сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр **34.4** сая төгрөг нийт **66.2** сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. 2017 оны 09 сарын орлогын гүйцэтгэлээс харахад рашаан ашигласны төлбөрийн орлого төлөвлөснөөс **23.7** хувиар давж биелж байгаа үзүүлэлттэй байна.

Аудитын талаар:

Аудитыг төсвийн орлого нэмэгдүүлэх санал гаргах зорилготойгоор гүйцэтгэсэн бөгөөд 2014-2017 оны ус, рашааны орлогын төлөвлөлт гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, болон Байгаль орчин аялал жуулчны газар болон, ОЧГСГЗ-ын мэргэжилтнүүдээс ирүүлсэн тоон баримт, судалгааг суурь үзүүлэлт болгон, Цэнхэр сумын **халуун рашааныг** түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа Жуулчны баазуудын **рашаан** ашигласны төлбөрийн орлогыг 2018 онд **26.2** сая төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоололыг хийж саналыг холбогдох байгууллагад уламжлаад байна.

Аудитаар нийт **2** байгууллагад **6** заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

БҮЛЭГ-1: 2014-2017 ОНУУДАД РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ БОДИТООР ТООЦООЛООГҮЙ БАЙНА

1.1. Холбогдох байгууллагууд хуулийн дагуу Ус, рашаан ашиглах дүгнэлтийг гаргаж ажиллахгүй байна.

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв цөөрөм байгуулах, суваг шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана” гэж заасан ч аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар болон Орхон чулуут голын сав газрын захиргаа нь аудитад хамрагдсан хугацаанд ус ашиглах дүгнэлтийг бүрэн гаргаж ажиллаагүй байна.

Рашаан ашигласны төлбөрийг аймгийн хэмжээнд 9 сумын 17 рашаан, рашаан төст булгуудад ногдуулж байгаа ч эдгээр рашаан, рашаан төст булгуудад эмчилгээний ач холбогдол болон рашааны чанар найрлага, нөөцийг тогтоосон гидрогеологийн болон бальнеологийн судалгааг хийлгэх шаардлагатай байна. Үүний үндсэн дээр рашаан ашиглах дүгнэлтийг гарган өгч, төлбөрийг ногдуулах нь зүйтэй.

Аудитад хамрагдсан ААНБ-уудаас аймгийн ОЧГСГЗ нь Цэнхэр сумын халуун **рашааныг** түшиглэн үйл ажиллагаа явуулж буй Хонгор тур ХХК-д үйл ажиллагааны чиглэлийг харгалзан холбогдох хуулийн дагуу 2017 онд рашаан ашиглах дүгнэлт гаргасан бол ЖДЛ ХХК, Өсгүүн ХХК-иудад **рашааны** төлбөрт ноогдуулалт хийснээс өөрөөр бусад томоохон ААНБ-уудад дүгнэлт гаргаагүй байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-1

Аудитад хамрагдсан халуун рашаан ашиглагч томоохон ААНБ-уудын дүгнэлт гаргасан байдал

№	Сумын нэр	ААНБ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Дүгнэлт гаргах байгууллага	Дүгнэлт гаргуулсан эсэх			
					2014	2015	2016	2017
1	Цэнхэр	Цэнхэр жигүүр /ЦЕТ/	Үйлдвэрлэл, үйчилгээ	Орхон чулуут голын сав газрын захиргаа	үгүй	үгүй	үгүй	жишиг татвар
2		Алтан нутаг /Зургаан эгшиг/			үгүй	үгүй	үгүй	жишиг татвар
3		Хангай ресорт /ЖДЛ/			үгүй	үгүй	үгүй	2017.08.31 /ногдуулалт
4		Шивээт манхан /Хонгор тур/			үгүй	үгүй	үгүй	2017.09.18 /дүгнэлт/
5		Дуут ресорт /Өсгүүн/			үгүй	үгүй	үгүй	2017.08.31 /ногдуулалт/
6	Батцэнгэл	Шивэрт	Эмчилгээ сувилгаа		тийм	тийм	тийм	тийм
8		Ахмадын амралт			үгүй	үгүй	үгүй	үгүй
9		Их-Улаанчулуут			үгүй	үгүй	үгүй	үгүй
10	Хотонт	Ар жарантай			үгүй	үгүй	үгүй	үгүй
11		Монказ			үгүй	үгүй	үгүй	үгүй

12		Их хаган хубилай	Үйлдвэрлэл, үйчилгээ		үгүй	үгүй	үгүй	үгүй
----	--	------------------	-------------------------	--	------	------	------	------

Дээрх хүснэгтээс харахад 2014-2016 онуудад эмчилгээ сувилгаа болон үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр **рашаан** ашиглаж байгаа ААНБ-уудад дүгнэлт гаргаагүй нь энэ талаарх мэдээлэл дутмаг байгаатай холбоотой байна.

Мөн аймгийн БОАЖГазар нь өнөөдрийн байдлаар ААНБ-уудад бүрэн хэмжээний дүгнэлт гаргаагүй байна.

Аудитад нийт 28 ус, рашаан ашиглагч ААНБ-ууд хамрагдсан бөгөөд эдгээрээс 17 ААНБ-уудад дүгнэлт гаргах ёстой боловч тухайн байгууллагууд холбогдох баримт материалыг мөн бүрэн бүрдүүлээгүйн улмаас Усны тухай хуулийн 28.4 дэх заалтыг хэрэгжүүлж, дүгнэлт гаргаагүй байгааг доорх хүснэгтээс харж болохоор байна.

Хүснэгт-2

Ус ашиглагч ААНБ-уудын БОАЖГ-аас дүгнэлт гаргасан байдал

№	Сумын нэр	ААНБ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Дүгнэлт гаргах байгууллага	Дүгнэлт гаргуулсан эсэх			
					2014	2015	2016	2017
1	Өгийнуур	Загасчин	Үйлдвэрлэл, үйчилгээ	Байгаль орчин аялал жуулчлалын газар	үгүй	үгүй	үгүй	үгүй
2		Гурвантамир			үгүй	тийм	үгүй	үгүй
3		Хатан-өгий			үгүй	тийм	үгүй	үгүй
4		Өгийтур			үгүй	тийм	үгүй	үгүй
5		Өгийндалай			үгүй	тийм	үгүй	үгүй
6	Ихтамир	Тунгалаг тамир	үгүй		үгүй	үгүй	үгүй	
7		Тайхар	үгүй		үгүй	үгүй	үгүй	
8		Эх байгаль	үгүй		үгүй	үгүй	үгүй	
9	Тариат	Их хоргын хишиг	үгүй		үгүй	үгүй	тоолууртай	
10		Эрхэм чулуут	үгүй		үгүй	үгүй		
11		Тэрх жуулчин	үгүй		үгүй	үгүй		
12		Үүрт туур	үгүй		үгүй	үгүй		
13		Цолмон трейвэл /Хорго/	үгүй		тийм	үгүй		
14	Хашаат	Цайдам	үгүй		үгүй	үгүй	тоолууртай	
15	Эрдэнэбулган	Гурван булган	үгүй		үгүй	үгүй		
16		Хавтгай мод	үгүй		үгүй	үгүй		
17		Чингисийн хүрээ	үгүй		үгүй	үгүй		

Судалгаанаас үзэхэд зарим жуулчны баазууд 2017 оноос эхлэн усны хэрэглээгээ хянахын тулд тоолууржуулж ажиллаж байна.

Мөн байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8-р зүйл¹ болон үнэлгээ хийлгэх байгууллагын хавсралтад зааснаар үйлчилгээний салбарын төрөлд ажиллаж буй ААНБ-ууд байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай бөгөөд тус хуулийн заалтыг аудитад хамрагдсан байгууллагууд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд аймгийн БОГ болон ОЧГСГЗахиргааны зүгээс дээрхи ус, рашаан ашиглагч ААН, байгууллагуудад усны дүгнэлтийг хуулийн дагуу гаргуулах, тэдгээрийг энэ талын мэдээлэлээр хангах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэх, рашаан рашаан төст булгуудын ач холбогдол болон рашааны чанар найрлага, нөөцийг тогтоолгох талаар арга хэмжээ авч биелэлтийг хангуулж ажиллах шаардлагатай байна

¹ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийх

Зөвлөмж: Аймгийн БОАЖГ болон ОЧГСГЗ-нд Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу ус, рашаан ашиглагч ААНБ-уудад ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулахын тулд холбогдох газруудад мэдээллийг бүрэн хүргэж, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

1.2. Ус, рашааны төлбөр хураамжийг холбогдох хуулийн хүрээнд төлөвлөж байгаа ч үндэслэл хангалтгүй байна.

Ус, рашаан ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4², 28.6³, 28.11⁴, 30 дүгээр зүйлийн 30.1.5⁵ дэх заалтуудын дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргуулан, зөвшөөрөл авч гэрээ байгуулснаар ус ашиглах эрх үүсч байна.

Уг дүгнэлтийн дагуу Байгаль орчны Сайдын 1995 оны 153 дугаар тушаалаар батлагдсан “нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах ус хэрэглээний түр норм”-ыг үндэслэн тухайн байгууллагын хоногийн усны хэрэглээг тооцож, Засгийн газрын 2011 оны “усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 302 дугаар, 2013 оны “усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” 326 дугаар, “ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг өөрчлөн батлах тухай” 327 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2012 оны 06 дугаар тогтоол зэргийг үндэслэн төлбөр хураамжийг ногдуулах ёстой.

Гэтэл 2014-2017 онуудад зарим ААНБ-аас авах **рашааны** хураамжийн тооцоолол, төлөвлөгөө үндэслэл муутай хийгдсэн гэж үзэхээр байна. Учир нь ИТХ-ын 2012 оны 06 дугаар тогтоол⁶ -ын дагуу **халуун рашаан ашиглагч үйлдвэрлэл үйлчилгээ** явуулж буй зарим ААНБ-аас шоо метрээр буюу 1500 төгрөгөөр тооцож авах ёстой боловч эмчилгээ сувилгаанд ашиглах төлбөрийн хэмжээгээр хүн хоног буюу хоног тутамд 500 төгрөг байхаар тооцож төлөвлөлт хийсэн байлаа.

Хүснэгтээр харуулвал:

Хүснэгт-3

2014-2017 онуудад Рашаан ашиглагч томоохон ААНБ-уудад төлбөрийн ногдуулалт хийсэн байдал

² 28.4.Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

³ 28.6.Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоометрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоометр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоометрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

⁴ 28.11.Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.

⁵ 30.1.5.ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх;

⁶ Аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа халуун болон хүйтэн рашаан ашигласны төлбөрийн хэмжээг эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглахад /нэг хүн/ хоног тутамд халуун рашааныг 500 төгрөгөөр, хүйтэн рашааныг 400 төгрөгөөр, үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтаар ашиглахад нэг шоометр тутамд халуун рашааныг 1500 төгрөгөөр, хүйтэн рашааныг 3000 төгрөгөөр тус тус тооцсугай.

Ашиглах рашааны хэмжээ / ИТХ-ын 2012 оны 06 тоот тогтоолын дагуу
500 төгрөгөөр тооцож төлөвлөлт хийсэн/

№	Сумын нэр	ААНБ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	2014		2015		2016		2017	
				хүн/ хоног	Төл /мян.төг/	хүн/ хоног	Төл /мян.төг/	хүн/ хоног	Төл /мян.төг/	хүн/ хоног	Төл /мян.төг/
1	Цэнхэр	Цэнхэр жигүүр /ЦЕТ/	Үйлдвэрлэл үйчилгээ	4700	2,350.0	5860	2,930.0	5000	2,500.0	5000	2,500.0
2		Алтан нутаг /Зургаан эгшиг/		4200	2,100.0	4400	2,200.0	5000	2,500.0	5000	2,500.0
3		Хангай ресорт /ЖДЛ/						5700	2,850.0	5700	2,850.0
4		Шивээт манхан /Хонгор тур/		5140	2,570.0	4400	2,200.0	6800	3,400.0	6800	3,400.0
5		Дуут ресорт /Өсгүүн/		5200	2,600.0	5000	2,500.0	6800	3,400.0	6800	3,400.0
6	Хотонт	Монказ	Үйлдвэрлэл үйчилгээ	2000	1,000.0	700	350.0	700	350.0	700	350.0
7		Их хаган хубилай		2000	1,000.0	600	300.0	600	300.0	600	300.0

Хүснэгтээс харахад Хотонт, Цэнхэр сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын гэрчилгээнд үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй ч төлбөрийг ногдуулж, төлөвлөлтийг хийхдээ эмчилгээ сувилгааны чиглэлээр тооцсон байна.

Мөн төлөвлөлтийг хийхдээ анхан шатны нэгжээс тооцоо судалгааг бүрэн авахгүйгээр өмнөх оны төлөвлөсөн тоо, хэмжээнд үндэслэн тооцсон байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал:

- Өгийнуур суманд 2014-2017 онд нийт 5 ААНБ үйл ажиллагаа явуулж төлбөрийг сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж байгаа боловч төлөвлөлтийг харахад 4 ААНБ-аар хийж гүйцэтгэсэн
- 2016 онд Батцэнгэл суманд шинээр 1 ААНБ үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч 2017 оны төлөвлөлтөнд оруулж тооцоолол хийгээгүй;
- 2015-2017 онуудад Чулуут, Хангай, Тариат, Цэцэрлэг, Батцэнгэл, Хотонт сумдын төлөвлөлтийг хийхдээ рашаан ашиглагч иргэдийн тоог огт өөрчлөөгүй байна. /БОАЖГ-аас ирүүлсэн албан бичгийг үндэслэв/

Цаашид холбогдох хуулийн дагуу аялал жуулчлалын бааз, рашаан сувилалын газруудын ус, рашааны шугам хоолой бүрийг тоолууржуулж ашиглалтын байдалд хяналт тавьж ус, рашааны төлөвлөлтийг хийх нь зүйтэй байна.

1.3. Хүн амын унд ахуй хэрэгцээний усыг хөнгөлж чөлөөлөхдөө холбогдох хуулийг мөрдөж байгаа ч бодитой тооцох нь зүйтэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1⁷, МУЗГ-ийн 2013 оны 326 дугаар тогтоолын 2-р хавсралтад заасны дагуу рашаан ус ашиглагч ААНБ-ын ажилчдын унд ахуйн зориулалтаар ашиглаж байгаа усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан нормын дагуу хөнгөлж чөлөөлөх ёстой боловч аудитад

⁷ Дараах зориулалтаар ус, ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө.

20.1.1. хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах

хамрагдсан зарим ААНБ-уудын хувьд уг хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэрхэн тооцсон нь тодорхой бус байна. Тухайлбал: 2015 онд 8, 2017 онд 1 ААНБ дүгнэлт гаргуулснаас өөрөөр хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлсэн баримт материал аудитын явцад шалгагдаагүй болно.

Цаашид ажилчдын унд ахуйн зориулалтаар хэрэглэх ус, үйлвэрлэлийн зориулалтаар ашиглах усны шугам хоолойг тусгаарлаж, хөнгөлөлт чөлөөлөлтийг бүрэн эдлүүлэх нь нь зүйтэй байна.

БҮЛЭГ-2: УС, РАШААН АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААМЖИЙГ ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ДАНСАНД БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЖ БАЙНА.

2.1. Ус, рашаан төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлжээ.

Орон нутгийн төсөв батлах аймгийн ИТХ-ын тогтоолоор ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг 2014-2017 онуудад дараах байдлаар батлаж гүйцэтгэлийг тайлагнаж ирсэн байна.

Хүснэгт-4

2014-2017 оны ус, рашаан ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл / мян төг/

№	Орлогын нэр төрөл	2014 он			2015 он			2016 он			2017 оны 09 сар		
		Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	ХБГ
1	Ус ашигласны төлбөр	62,500.0	100,675.6	38175,6	59,520.0	84,278.4	24754,4	295,635.3	351,351.4	55716,1	188,323.2	31,816.8	188,323.2
2	Рашаан ашигласны төлбөр	28,500.0	33,319.1	4819,1	22,480.0	28,653.5	6173,5	27,800.0	24,705.9	(3094,1)	27,800.0	34,478.2	34,478.2
НИЙТ ДҮН		91,000.0	133,994.7	42994,7	82,000.0	112,931.9	30931,9	323,435.3	376,057.3	52622	216,123.2	66,295.0	216,123.2

Хүснэгтээс харахад:

Ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт жилээс жилд нэмэгдэж гүйцэтгэлээр ч орлого давж байна. 2014-2016 онд ус ашигласны төлбөрийн орлого **38.1-55.7** сая төгрөг буюу **18.8-60** хувиар давсан бол 2017 онд Ус ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулахад мөн адил давж биелэх магадлалтай байна.

Харин 2014-2015 онд рашаан ашигласны хураамж **4.8-6.1** сая төгрөг буюу **16.8-27.6** хувиар давсан бол 2016 онд **3.0** сая төгрөгөөр тасарсан байгаа ч 2017 оны ХБГ-ээр тооцоход рашаан ашигласны төлбөрийн орлого **6.6** сая төгрөг буюу **23.7** хувиар давж биелэхээр байна.

Аудитад хамрагдсан нийт 28 ААНБ-ын орлогыг жил тус бүрээр харуулбал орлого хичнээн давж биелж байгаа ч төлөвлөлтийг зөвхөн өмнөх оны тоо, хэмжээний мэдээлэлд суурилж, шахуу төлөвлөөгүйгээс орлого нэмэгдэх боломжийг алдсан байна.

2014-2017 оны Ус, рашаан ашиглагч байгууллагын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Сумын нэр	ААНБ-ын нэр	Төлбөр төлсөн байдал /мян.төг/							
			2014		2015		2016		2017,09	
			Төл*	Гүйц	Төл*	Гүйц	Төл*	Гүйц	Төл*	Гүйц
1	Цэнхэр	Цэнхэр жигүүр /ЦЕТ/	2,350.0	3,707.0	2,930.0	2500.0	2,500.0	3,477.0	2,500.0	5,315.0
2		Алтан нутаг /Зургаан эгшиг/	2,100.0	2,100.5	2,200.0	2,117.4	2,500.0	2500.0	2,500.0	4,500.0
3		Хангай ресорт /ЖДЛ/					2,850.0	2,500.0	2,850.0	2,160.0
4		Шивээт манхан /Хонгор тур/	2,570.0	3,875.7	2,200.0	2,836.8	3,400.0	3,470.0	3,400.0	4,000.0
5		Дуут ресорт /Өсгүүн/	2,600.0	2,600.0	2,500.0	2,000.0	3,400.0	3,780.5	3,400.0	6,016.1
6	Батцэнгэл	Шивэрт	6,500.0	6,505.6	5,000.0	5,565.0	5,000.0	5,565.0	5,000.0	5,565.0
7	Хотонт	Ар жарантай	1,000.0	1,703.2	350.0	1000.0	350.0	1000.0	350.0	350.0
8		Монказ	1,000.0		350.0		350.0		350.0	300.0
9		Их хаган хубилай	1,000.0		300.0		300.0		300.0	300.0
10	Өгийнуур	Загасчин	212.1	200	192.0	200	192	192	192	100
11		Гурвантамир	212.1	192	160.0	160	160	160	160	100
12		Хатан-өгий	212.1	200	212.6	212.6	212.6	212.6	212.6	100
13		Өгийтур	212	200	159.2	150	159.2	159.2	159.2	100
14		Өгийндалай		100		100		67.2		200
15	Ихтамир	Тунгалаг тамир	144.6	144.6	154.3	154.3	154.3	154.3	154.3	617.2
16		Тайхар	144.6	144.6	144.6	144.6	154.3	154.3	154.3	
17		Эх байгаль	144.6	144.6	144.6	144.6	154.3	154.3	154.3	
18	Тариат	Их хоргын хишиг	266.4	266.4	266.4	266.4	266.4	266	266.4	932.5
19		Эрхэм чулуут	131.5	131.5	131.5	131.5	131.5	131.5	131.5	
20		Тэрх жуулчин	200	200	200	200	200	200	200	
21		Үүрт туур	160.3	160.3	160.3	100	160.3	100	160.3	
22		Цолмон трейвэл /Хорго/	271.8	271.8	271.8	105.7	271.8	105.7	271.8	
23	Хашаат	Цайдам	80		80		80		80	80
26	Эрдэнэбулган	Гурван булган								
27		Хавтгай мод								
28		Чингисийн хүрээ								

*Төлөвлөлтийг үндэслэлийг 1.2 бүлэгт дурьдсан болно

Аудитын зүгээс төлөвлөлтийн үндэслэл сайтай хийгдсэнээр **рашаан** ашигласны төлбөр хураамж нэмэгдэнэ гэж урьдчилан тооцоолж байна. Учир нь 2017 оны 09 сарын байдлаар Цэнхэр суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудын орлогын төлөвлөгөө **7.3** сая төгрөг буюу 50 хувиар давж биелэсэн нь цаашид орлого давж биелэх боломж байгааг харуулж байна. Иймд 2018 оны төсвийн төсөлд **рашаан ашигласны төлбөрийн** орлогыг **26.2** сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг холбогдох газруудад уламжилж байна. /Холбогдох тооцоололыг хавсаргав/

2.2. Орлого төвлөрүүлэлтэд аймаг, сумдын татварын хэлтэс болон холбогдох мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллаж байна.

Ус, рашаан ашигласны төлбөр хураамжийг төвлөрүүлэхэд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13-р зүйл⁸-д заасны дагуу аймаг сумдын байгаль орчны улсын байцаагч болон татварын байцаагч нар холбогдох хууль эрхзүйн хүрээнд ажиллаж байна. Мөн ОЧГСГЗ-аас ус, рашаан ашиглагч ААНБ-уудад ус ашиглуулах дүгнэлт болон ус, рашааны төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх зөвлөмж хүргүүлсэн байна.

БҮЛЭГ-3: НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ТООЦОХГҮЙ БАЙГАА Ч ТӨЛӨВЛӨСӨН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

3.1 Нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцохгүй байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг 35% гэж заасан байдаг. Энэхүү төлбөрийн орлогыг “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.2 дахь заалтын дагуу орон нутагт усны нөөцийн хайгуул судалгаа, ус цэнгэгжүүлэх, хэмнэх дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн бусад арга хэмжээнд зарцуулахаар тусгагдсан.

2014-2017 оны төлбөрийн орлогыг хуулийн дагуу байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 39.5-131.6 сая төгрөг буюу өссөн дүнгээр нийт 241.2 сая төгрөг төвлөрүүлэн, зарцуулахаас дээрхи онуудад нийт 151.0 сая төгрөгийг баталж, 37 хувиар дутуу төлөвлөн зарцуулсан байна.

Хүснэгт-6

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал /мян.төг/

№	Ус, рашаан ашигласны төлбөр	хувь	орлогын			БХСанд төвлөрвөл зохих дүн	Батлаж зарцуулсан дүн	Хувь
			төлөвлөгөө /мян.төг/	гүйцэтгэл /мян.төг/	зөрүү			
1	2014	35	91,000.0	133,994.7	42,994.70	46,898.15	48,000.0	102
2	2015		82,000.0	112,931.9	30,931.90	39,526.17	36,500.0	92
3	2016		323,435.3	376,057.3	52,622.00	131,620.06	36,000.0	27
4	2017-9 сар		216,123.2	66,295	(149,828.20)	75,643.1*	30,500.0	40.3
НИЙТ ДҮН			712,558.5	689,278.9	(23,279.6)	241,247.6	151,000.0	63

*хүлээгдэж буй гүйцэтгэлээр

⁸ Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын татварын алба, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хяналт тавина.

Зарцуулалтыг харахад ЗГ-ын 2014 оны 43-р тогтоолын 3.2⁹-т заасан арга хэмжээнүүдэд буюу усны хөв байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах, усны тоо бүртгэлийн мэдээллийг хийх, Цэнхэр сумын халуун рашааны эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх зэрэг төсөл арга хэмжээнүүдэд зарцуулахаар төлөвлөж зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

3.2. Ус, рашаан ашиглагч ААНБ-уудын үйл ажиллагаанд холбогдох байгууллагууд бүрэн хяналт тавьж ажиллаж байна.

Усны тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд аймгийн БОАЖГ болон ОЧГСГЗ нь ус, рашаан ашиглагч ААНБ-уудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Мөн аймгийн МХГ хяналтыг нэгэн адил хэрэгжүүлэх ёстой боловч аялал жуулчлалыг эрсдэл багатай гэж үзэн аудитын хамаарах хугацаанд хяналтыг хэрэгжүүлээгүй, Цэнхэр сумын Орхон багт үйл ажиллагаа явуулж буй алт олборлогч ААНБ-уудад удаа дараа усны хяналт шалгалт хийж, ажлын тайлан мэдээ зэргийг гаргаж ажилласан байгаа ч тус баримт материал аудитад хамрагдсангүй.

Харин ОЧГСГЗ болон БОАЖГ-аас жил бүр хяналт шалгалтыг хийж холбогдох хууль эрхзүйн хүрээнд ажиллах заавар зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Тус байгууллагууд өөрийн бүрэн эрхийн хүрээнд 2016 онд Эрдэнэбулган, Өгийнуур суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-дад, 2017 онд Цэнхэр суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад хамтарсан шалгалт хийж Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, ус ашиглагч ААНБ-уудад ус, рашааны нөөц ашиглуулах дүгнэлт, гэрээ зөвшөөрөл болон бичиг баримтын бүрдэл зэргийг нягталж холбогдох хүмүүст үүрэг өгч хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

Цаашид холбогдох байгууллагууд /ОЧГСГЗ болон БОАЖГ/ ААНБ-дад өгсөн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж Ус, ашиглах дүгнэлтийг гаргах дүгнэлт гаргах боломжгүй тохиолдолд тоолууржуулах, жил бүр усны тоо бүртгэлийн ажлыг тогтмолжуулах, орлогыг бодитоор тооцох, ААНБ-уудын бичиг баримтын бүрдлийг бүрэн болгож, байгаль орчинд нөлөөлөх үнэлгээг хийлгүүлэх, улмаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад Байгаль орчны аудит хийлгэхийг уламжилж байна.

⁹ 3.2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.3-т заасныг үндэслэн:

3.2.1. усны сав газарт усны нөөцийн хайгуул судалгаа, зураглал хийх, усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд хяналт-шинжилгээ явуулах, усны тоо бүртгэл хийх;

3.2.2. усны үр ашигтай, хэмнэлттэй хэрэглээг болон хаягдал усыг дэвшилтэт технологиор цэвэрлэх, тоолууржуулах, унд-ахуйн ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг шинэчлэх, засч сэлбэхийг дэмжих, ундны ус цэнгэгжүүлэх, усны хяналт шинжилгээний болон лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, хаягдал ус зайлуулах цэгийг сайжруулах;

3.2.3. Усны тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дүрэм журмыг мөрдүүлэх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн заагийг тэмдэгжүүлэх, хаалт, хамгаалалт хийх, тохижуулах;

3.2.4. усны сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

3.2.5. усны сав газрын байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, цас, борооны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, рашаан, гол мөрний урсац бүрэлдэх эх, булаг шанд, баянбүрдийг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд тус тус зарцуулна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

2. 2014-2017 онуудад Рашаан ашигласны төлбөр хураамжийг бодитоор тооцоолоогүй байна

1.1. Холбогдох байгууллагууд хуулийн дагуу Ус, рашаан ашиглах дүгнэлтийг гаргаж ажиллахгүй байна.

1.2. Ус, рашааны төлбөр хураамжийг холбогдох хуулийн хүрээнд төлөвлөж байгаа ч үндэслэл хангалтгүй байна.

1.3. Хүн амын унд ахуй хэрэгцээний усыг хөнгөлж чөлөөлөхдөө холбогдох хуулийг мөрдөж байгаа ч бодитой тооцох нь зүйтэй байна.

3. Ус, рашаан ашигласны төлбөр хураамжийг орон нутгийн орлогын дансанд бүрэн төвлөрүүлж байна

2.1. Ус, рашаан төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлжээ.

2.2. Орлого төвлөрүүлэлтэд аймаг, сумдын татварын хэлтэс болон холбогдох мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллаж байна.

4. Нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцохгүй байгаа ч төлөвлөсөн хөрөнгийн зарцуулалт үр дүнтэй байна.

3.1. Нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцохгүй байна.

3.2. Ус, рашаан ашиглагч ААНБ-уудын үйл ажиллагаанд холбогдох байгууллагууд бүрэн хяналт тавьж ажиллаж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга Н.Баянмөнх танаа:

1. Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу хоногт 50м^3 –ээс доош **ус** ашиглаж байгаа аж ахуй нэгж байгууллагуудыг бүрэн хамруулж, ус ашиглах дүгнэлтийг гаргаж, мэдээллээр хангаж ажиллах
2. Ус, рашаан ашигласны төлбөр хураамжийн төлөвлөгөөг анхан шатны нэгжээс ирүүлсэн тооцоо судалгааг үндэслэн оновчтой хийж хэвших.
3. Байгаль орчны аудит, болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх саналыг хуулийн дагуу Мэргэжлийн байгууллагад уламжлах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлснээр ус, рашаан ашиглагч байгууллагуудад хуулийн хүрээнд дүгнэлт гаргаж хэвшиж, ашиглах усны хэмжээ тодорхой болж төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэмэгдэх мөн хуулийн дагуу Байгаль орчны аудит хийгдсэнээр байгаль орчны унаган төрхийг хадгалах, байгаль экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх үр дүнтэй байх болно.

Орхон чулуут голын сав газрын захиргааны дарга Ч.Отгонбаатар танаа:

1. Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу хоногт $50-100\text{м}^3$ **ус** ашиглаж байгаа аж ахуй нэгж байгууллагын ус, рашаан ашиглах дүгнэлтийг гаргаж, мэдээллээр хангаж ажиллах
2. Аймгийн хэмжээнд халуун болон хүйтэн рашааныг түшиглэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад **рашаан** ашигласны дүгнэлтийг гаргуулах, рашаан ашигласны төлбөр хураамжийг бодитойгоор тооцоолж байх
3. Байгаль орчны аудит, болон Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх саналыг хуулийн дагуу Мэргэжлийн байгууллагад уламжлах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлснээр ус, рашаан ашиглагч байгууллагуудад хуулийн хүрээнд дүгнэлт гаргаж хэвшиж, ашиглах усны хэмжээ тодорхой болж төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэмэгдэх мөн хуулийн дагуу Байгаль орчны аудит хийгдсэнээр байгаль орчны унаган төрхийг хадгалах, байгаль экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх үр дүнтэй байх болно.

УЛАМЖЛАХ САНАЛ

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Мөнхнасан танаа.

2014-2017 оны ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтийн байдалд хийсэн нийцлийн аудитын дүнгээс дараах хоёр саналыг уламжилж байна.

Архангай аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд алт олборлох үйл ажиллагаа эрчимтэй нэмэгдэж, алт олборлогч аж ахуй нэгжүүд гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайж хүрээлэн буй орчныг ихээхэн сүйтгэж, байгалийн тэнцвэрт байдлыг маш ихээр алдагдуулж, холбогдох хууль дүрмийг ноцтой зөрчсөөр байна.

Энэ нь áàèǎëü î ð÷èí âî ëî í òǵí, малын ýðǵǵè ì ýí âýä ñ° ð° âí °è°° үзүүлж, үүнээс болж их хэмжээний õî ðèõî è, ǵð äàǎǎâäð үүсч болзошгүй байна.

Иймд

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-р зүйлд зааснаар **аймгийн хэмжээнд мэргэжлийн байгууллагуудаар** байгаль орчныг аудитыг **хийлгэж нэгдсэн дүгнэлт гаргуулан ажиллах** нь зүйтэй байна.

Áàéǵëüî ð÷í û àòàèòí û òòòàéí áàéǵòëèàǵüí áàéǵëüî ð÷èí à ó÷ðóóëæáí èí ò àèèààà ñ° ð° áí °è°°, õî òèðî è, çð ààǵǵàðüî áàðèèèǵð àðǵǵ õýì æýýàǵààð, çéèǵáýð, àæ àðóéí í ýǵæ, áàéǵòëèàǵüí ýéí èí æ ýáèéí çàñǵéí çð äçí āāýýø èççýýð, óèì ààð áàéǵëüî ð÷èí à áí èí í òçí èé ýðççè ì ýí äýä ñ° ð° áí °è°° ǵé àðǵǵàð çéèǵáýðèýé ýáóóèàòàà çéèǵáýð, àæ àðóéí í ýǵæ, áàéǵòëèàǵǵ, èðǵýäýä òñèàð, òýáí èéǵ ó÷èð÷ áí èí ò àèàǵǵàè, õî òèðèíîñ сэргийлдэгээрээ ач холбогдолттой юм.

- Бид энэхүү аудитыг төсвийн орлого нэмэгдүүлэх санал гаргах зорилготойгоор гүйцэтгэсэн бөгөөд 2014-2017 оны ус, рашааны орлогын төлөвлөлт гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл болон Байгаль орчин аялал жуулчны газар, ОЧГСГЗ-ын мэргэжилтнүүдээс ирүүлсэн тоон баримт, судалгааг суурь үзүүлэлт болгон Цэнхэр сумын **халуун рашааныг** түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа Жуулчны баазуудын рашаан ашигласны төлбөрийн орлогыг 2018 онд **26.2** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэсэн саналыг холбогдох тооцоололын хамт уламжилж байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/29

Цэцэрлэг

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 тушаалын 5 дугаар хавсралтын 1.2 дахь заалт, 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ын 9 дахь заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2017 оны 06 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу 2014-2017 оны Ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтийн байдал /Жуулчны баазуудад/ хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ, Засаг дарга, БОАЖГ, ОЧГСГЗ-нд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг нийцлийн аудитын багийн аудитор /Х.Алтанчимэг/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторов 2017 оны ^{11/29} дугаар тушаалын
хавсралт

№	Зөвлөмжийн		Хэрэгжүүлэх албан тушаалтан
	Дугаар	Утга	
1	01/11	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай	ОЧГСГЗахиргааны дарга Ч.Отгонбаатар
2	02/12	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай	БОАЖГ-ын дарга Н.Баянмөнх

Жагсаалт гаргасан: Аудитор



Х.Алтанчимэг